

Эхийн эрүүл мэндийг хамгаалахад эрчүүдийн туслалцаа, дэмжлэг чухал

Жил бүрийн 7 дугаар сарын 11-ны өдөр дэлхий даяар Дэлхийн хүн амын өдрийг тодорхой сэдэв, уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай бөгөөд энэ жилийн хувьд “Эхийн эрүүл мэндийг хамгаалахад эрчүүдийн туслалцаа, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэнэ” хэмээх уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Эх болгон эрүүл, аз жаргалтай, сэтгэл түвшин байхад эрчүүдийн гэр бүл, хань, үр хүүхдүүддээ үзүүлэх халамж дэмжлэг чухал болохыг онцлон тэмдэглэж байна.

1. Эхийн эрүүл мэндийн талаар

Дэлхийн хэмжээнд хором тутам нэг эмэгтэй хүүхэд төрүүлэхдээ энддэг. Хором тутамд эхийгээ алдсан гэр бүл хагацлын зовлон амсч, амьд үлдсэн хүүхдийн эрүүл мэндэд аюул заналхийлж байдаг. Хэдийгээр энэ талаар төр засаг болон олон улсын байгууллагуудаас ихээхэн анхаарал тавьж, олон хэлбэрийн арга хэмжээ авч байгаа боловч, янз бүрийн шалтгааны улмаас хүлээн зөвшөөрч боломгүй олон тооны эмэгтэй хүүхдээ төрүүлэхдээ эндэж, эсвэл эрүүл мэндээрээ хохирч байна. Жендэрийн талаарх хуучинсаг үзэл хандлагын улмаас эхийн эрүүл мэндийн асуудал эн тэргүүнд анхаарах асуудлын нэг байж чадахгүй байна.

НҮБ-ын Хүн амын сан эхийн эндэгдийг бууруулах чиглэлээр:

- Эмэгтэй хүн бүрт гэр бүлээ төлөвлөх, хүсээгүй жирэмслэхээс хамгаалах орчин үеийн хэрэгслийг ашиглах боломжийг олгох;
- Жирэмсэн эх болгон төрөхдөө мэргэжлийн эмчийн туслалцааг авах боломжтой байх;
- Хүндрэлтэй эх болгон эх барихын яаралтай чанартай туслалцааг цаг алдалгүй авах боломжтой байх гэсэн гурван талт стратеги баримтлан ажиллаж байна.

НҮБ-ын Хүн амын сангийн дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн хүрээнд эрэгтэй хүний тухай хуучинсаг ойлголтыг өөрчлөх, эрэгтэйчүүдийн эрсдэлтэй зан үйл, ялангуяа бэлгийн зан үйлийг судлах, жендэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр өсвөр үеийнхэн болон залуучуудтай хамтран ажилладаг.

“Энэ жил Эсэн мэнд амаржихуйн санал санаачлага гарсны 20 жилийн ой тохиож байгаатай холбоотой эмэгтэйчүүд, эхчүүдийн эрүүл мэндийн аюулгүй байдалд анхаарал хандуулах онцгой чухал цаг үед тулж ирээд байна. Эхчүүдийн эрүүл мэндийг хамгаалах нь алсдаа тэдний үр хүүхэд, гэр бүлийн эрүүл мэндийг хамгаалах чухал арга зам болдог. Дэлхийд нэг жилд хагас сая эмэгтэй төрөх, эсвэл жирэмсний хүндрэлээс нас барж, хагас сая хүүхэд эхийн хайр, халамжаас ангид үлдэж байгаа нь бодит эмгэнэл юм. Үүнийг мөсөн уултай зүйрлэвэл зөвхөн оройн хэсэг л юм. Мөн эндээж буй эмэгтэй тутамд насан туршийн өвчин эмгэгтэй үлдэж байгаа 20-30 эмэгтэй ногдож байна. Өнөөдөр жирэмсний болон хүүхэд төрүүлэх үеийн хүндрэл хөгжиж буй орнуудын 15-19 насны охид, эмэгтэйчүүдийн эндэгдлийн зонхилох шалтгаан болж байна”

2. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд эрчүүдийн оролцоо

А. Эрэгтэйчүүдэд шийдвэр гаргах эрх мэдэл байдаг

Эрчүүдэд эцэг, өрхийн тэргүүн, нөхөр, нийгэм улс төрийн манлайлагч, шашны тэргүүн гээд гэр бүл болон нийгэмд гүйцэтгэж байгаа үүргийнхээ хүрээнд шийдвэр гаргах олон эрх мэдэл байдаг. Иймээс хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, ХДХВ-ийн халдвараас сэргийлэхийн тулд жирэмслэхээс хамгаалах хэрэгсэл, бэлгэвч хэрэглэх үү үгүй юу? Эх төрөх үедээ мэргэжлийн эмч, эх баригчийн туслалцааг авах уу? Яаралтай тусламж хэрэгтэй үед

унаа болон эмнэлгийн тусламжийн зардал гаргах уу? Хүүхдүүд чинь бага болон дунд, дээд сургууль төгсөх үү? Охин чинь өөрөө амьдралынхаа сонголтыг хийх үү, эсвэл эцэг эхийн зааснаар явах уу? зэрэг асуултуудад эрэгтэйчүүд хэрхэн хандахаас эмэгтэйчүүдийн амьдрал, эрүүл мэнд ихээхэн хамаардаг.

Гэр бүлээ төлөвлөх, эмнэлэг болон хүүхдийн сургуулийн төлбөр гэх мэт айл гэрийн санхүүг хэрхэн хуваарилах талаар голчлон нөхөр нь шийдвэр гаргадаг. Түүний гаргасан шийдвэрээс нийт гэр бүлийн сайн сайхан, ирээдүй ихээхэн шалтгаална. Мэдээлэл сайтай, хандлага зөвтэй нөхрийн халамж, дэмжлэг нь жирэмсэн болон төрсний дараа эмэгтэй хүнд маш чухал бөгөөд хүндрэл гарсан үед буюу эмэгтэйд эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай үхэл амьдралын эгзэгтэй үед зөв шийдвэрийг цаг алдалгүй гаргахад шаардлагатай.

Б. Хамтарч ажиллах нь эрэгтэйчүүдэд ч ашиг тустай

НҮБ-ын Хүн амын сангийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, эрчүүд болон тэдний хамтран амьдрагчдыг эрсдэлд оруулах “жинхэнэ” эр хүний тухай хуучинсаг ойлголтуудыг халах боломжийг олгодог. Эрэгтэйчүүд өөрийн эрүүл мэндийн хэрэгцээг мэдээд зогсохгүй өөрсдийг нь жинхэнэ хариуцлагатай эр хүн болгох зан үйл, үйл ажиллагаа, үүргийн талаар мэдлэгтэй болж, амьдралдаа хэрэгжүүлэх чадварыг эзэмшинэ. Тэд хариуцлагатай, халамжтай, хүчирхийллээс ангид аав, ах, нөхөр, найз залуу байхын ач тусыг ойлгож авна. Бүх эрчүүдийн хувьд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйл ажиллагаанд оролцсоноор хайртай хүнтэйгээ зөвлөлдөж, хамтран шийдвэр гаргаж хүссэн үедээ үрээ тэврэх, аюулгүй бэлгийн харьцаанд орох, БЗДХ/ХДХВ-

ийн халдвараас өөрийгөө болон хайртай хүмүүсээ хамгаалах, шаардлагатай үедээ зөв оношлогоо хийлгэж, эмчлүүлэх боломжийг олгож байна.

Жирэмсэн эх дараахь шалтгааны улмаас эндсэн тохиолдол байсаар байна.

- Ар гэр нь боломжгүйгээс аймгийн төвийн эмнэлэг рүү яваагүй—
- Нэн ядуу, эрүүл мэндийн даатгалгүй гээд эмнэлэгт хандаагүй
- Жирэмсний хяналтанд хожуу эсвэл бүр ороогүй
- Биеийн байдал хэт хүндэрсэн хойно эмнэлэгт хандсан
- Эхийн амрах байранд очилгүй гэртээ төрж нас барсан
- Өөрөө дур мэдэж үр хөндөх зорилгоор эм уусан, өндрөөс үсэрсэн
- Аюултай үр хөндөлт хийгдээд эмнэлэгт хандаагүй удсан
- Гэр бүлийн маргааны улмаас эмнэлэгт оройтож хандсан
- Үр хүндүүлснээ ар гэрийнхэндээ хэлэлгүй хүндэрсний дараа эмнэлэгт хандсан
- Мэргэжлийн бус хүнээр гэрийн нөхцөлд жирэмсэнг таслах оролдлого хийлгэсэн

“Яагаад эх эндэв судалгааы тайлан”, 2006, ЭНЭШТ

3. Бодлого, зорилго

А. Эрэгтэйчүүдийн оролцооны талаар НҮБ-ын Хүн амын сангийн баримтлах бодлого

Жендэрийн тэгш оролцоо, тэгш байдлыг хангах, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд зөвшилцсөн шийдвэр гаргахад эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй хамтран ажиллахыг НҮБ-ын ХАС дэмждэг. Энэ үйл ажиллагааныхаа хүрээнд эмэгтэй хүний эрхийг хүндэтгэх, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх, эхийн эндэгдэл болон өвчлөлийг багасгах, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулахад эрчүүд гүйцэтгэх үүргээ ойлгож ухамсарлахад нь дэмжлэг үзүүлэх, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах,

хамтрагчдынхаа бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээг хүртэхэд нь дэмжлэг үзүүлдэг, гэр бүлийн болон хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргийг хамтран биелүүлдэг хандлага төлөвшүүлэх, жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхах явдлыг устгахад чиглэгдсэн үйл ажиллагаанд мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллана.

Монгол улсын хувьд 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2000 онд 158 байсан нь 2005 онд 93 болсон нь нааштай үзүүлэлт юм. Эхийн эндэгдэл үндэсний хэмжээнд тууштай буурсаар байгаа ч зарим газар, нэн ялангуяа баруун бүсийн алслагдсан аймгуудад өндөр хэвээр байна. Төрж буй эхчүүдийн 30 хувь, эхийн эндэгдлийн 28.6 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээнээс алслагдмал малчин өрхөд тохиолдож байгаа юм. Эхийн эндэгдлийн шалтгаанд жирэмсэн үеийн хүндрэл 23.8 хувь, төрөх үеийн хүндрэл 16.6 хувь, төрсний дараахь хүндрэл 26.2 хувь, жирэмсэн, төрөлттэй холбоогүй өвчин 33.3 хувь эзэлж байна /Эрүүл мэндийн үзүүлэлт 2005/. Улсын хэмжээнд эхийн амрах байр 339 ажиллаж байгаа бөгөөд эхийн амрах байрны ач холбогдлыг эхчүүд болон тэдний гэр бүлийнхэн дутуу үнэлдэгээс амарвал зохих эхчүүд бүрэн хамрагдаж чадахгүй байна.